



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/129

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 5 сарын 5-ны өдрийн 71 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын дүгнэлт, Луус сумын ИТХ-ын саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Луус сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан байршилд тогтоосон хэмжээ, солбицолын дагуу Өгөөжтэй баялаг жонш ХХК-д 3 жилийн хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, энэ тухай холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Өгөөжтэй баялаг жонш ХХК-ний захирал (Д.Төртогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010376

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар
сарын 06-ны өдрийн 169 дугаар
захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТАЛБАЙ

Д/д	Өргөдлийн дугаар	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Талбайн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ га
1.	ХА-48000096-001-NE	Луус	"Өгөөжтэй баялаг жонш" ХХК	Хар толгой	105° 40' 51.8"	45° 49' 47.56"	399.73
					105° 40' 51.81"	45° 50' 25.13"	
					105° 40' 16.53"	45° 50' 20.18"	
					105° 40' 0.54"	45° 50' 39.28"	
					105° 40' 51.82"	45° 50' 46.66"	
					105° 40' 51.82"	45° 50' 52.96"	
					105° 39' 5.8"	45° 50' 52.96"	
					105° 39' 5.82"	45° 49' 47.56"	